

2019 оны ... сарын
...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИТГЭЛИЙН ЗЭЭЛ ОЛГОХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь өрхийн аж ахуй болон бичил бизнес эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэхээр итгэлийн зээл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Итгэлийн зээл олгох тухай хууль тогтоомж

2.1.Итгэлийн зээл олгох тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Банкны тухай хууль, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн хамрах хүрээ

3.1.Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн /цаашид " иргэн" гэх/ -д энэ хуулийн зохицуулалт хамаарна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."итгэлийн зээл" гэж өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгч бага орлоготой иргэнд барьцаа хөрөнгө шаардахгүй, санхүүгийн уян хатан нөхцөлтэй зээл олгохыг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ ИТГЭЛИЙН ЗЭЭЛ

5 дугаар зүйл.Итгэлийн зээл олгох нөхцөл

5.1.Энэ хуулийн 4.1.1-д заасан зээлийг авах иргэн дараах нөхцөлийг хангасан байна:

5.1.1.Монгол Улсын иргэн, 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай;

5.1.2.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

5.1.2.өрхийн аж ахуй болон бичил бизнес эрхлэх бизнес төлөвлөгөөтэй байх;

~~5.1.3.өрлөгийн төгтвөртэй эх үүсвэртэй гуравдагч этгээд батлан даалт гаргасан байх;~~

5.1.4.зээлдэгч өөрөө хүсвэл барьцаа хөрөнгө тавих;

5.1.5.санхүүгийн суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсан байх;

5.2.Иргэн энэ хуулийн 4.1.1-т заасан зээлийг хугацаандаа эргэн төлсөн тохиолдолд дахин зээл авах эрхтэй.

6 дугаар зүйл.Итгэлийн зээл олгох санхүүгийн байгууллага

6.1.Монгол Улсын Засгийн газраас хууль тогтоомжид заасны дагуу үүсгэн байгуулсан банкнаас энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан иргэнд итгэлийн зээлийг олгоно.

6.2.Итгэлийн зээл нь жилийн 3 хувийн хүүтэй, 36 сар хүртэл хугацаатай байна.

6.3.Эргэн төлөлт, зээлийн батлан даалт болон зээл олгохтой холбогдсон бусад харилцааг нарийвчлан зохицуулсан Итгэлийн зээлийг олгох тухай журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

7 дугаар зүйл.Итгэлийн зээлийн сан

7.1.Итгэлийн зээлийн сангийн хөрөнгө нь олон улсын байгууллагаас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, Засгийн газраас гаргасан бонд, Засгийн газрын тусгай сан, улсын төсөв, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

8 дугаар зүйл.Итгэлийн зээлийн хэмжээ

8.1.Итгэлийн зээлийн дүн хорин сая төгрөг хүртэл байна.

8.2.Итгэлийн зээлийн доод дүнг энэ хуулийн 6.2-т заасан журмаар зохицуулна.

9 дүгээр зүйл.Итгэлийн зээлийн үйл ажиллагаанд хориглох зүйл

9.1.Итгэлийн зээл олгоход хуульд зааснаас бусад нөхцөл, шаардлага тавихыг хориглоно.

9.2.Иргэн энэ хуулийн 4.1.1-т заасан зээлийг зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.

9.3. Иргэн энэ хуулийн 4.1.1-т заасан зээлийг мансууруулах бодис, зэвсэг, тамхи, хортон шавьж устгах бодис, химийн бордоо болон бусад хууль бус үйл ажиллагааг эрхлэхэд ашиглахыг хориглоно.

9.4. Энэ хуулийн 6.1-т заасан санхүүгийн байгууллага нь энэ хуулийн 4.1.1-т заасан зээлийг хугацаанд нь эргэн төлөөгүй иргэний зээлийн мэдээллийг Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан хугацаанд хадгалж дахин зээл олгохыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

10 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

10.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

11 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

11.1. Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... сарын
...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн тухай тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

"19.5.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь Итгэлийн зээл олгох тухай хуулийн 4.1.1-т заасан зээлийн мэдээллийг уг санд хүлээн авсан өдрөөс хойш 20 жилийн хугацаанд хадгална."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Итгэлийн зээл олгох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... сарын
...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

"9.1.3.Итгэлийн зээл олгох тухай хуулийн 4.1.1-т заасан зээл авах иргэнд энэ хуулийн 9.1.1-т заасан хувиар батлан даалт гаргах;"

2 дугаар зүйл.Энэ хуулийг Итгэлийн зээл олгох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... сарын
...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Арван нэгдүгээр бүлэгт доор дурдсан агуулгатай 11.32 дахь зүйл нэмсүгэй:

"11.32 дугаар зүйл.Итгэлийн зээл олгох тухай хууль зөрчих

1.Өөрийн авсан зээлийг зориулалтын бусаар, мансууруулах бодис, зэвсэг, тамхи, хортон шавьж устгах бодис, химийн бордоо болон бусад хууль бус үйл ажиллагаа эрхлэхэд ашигласан хүнийг ... нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Зээл олгоход хуульд зааснаас бусад нөхцөл, шаардлага тависан бол хуулийн этгээдийг ... нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Итгэлийн зээл олгох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг